



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн
номд тавих шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн номд тавих шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010280

Боловсролын сайдын 2026 оны 05
дугаар сарын 16 өдрийн 4/81 дугаар
тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН НОМД ТАВИХ ШААРДЛАГА

Энэхүү шаардлага нь багшийн номын агуулга, арга зүй, үнэлгээ, хэл найруулга, дизайн, нэмэлт материалд хамаарна.

Шаардлагыг багшийн номын зохиогч, шинжээч, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэвлэлийн газар ашиглана.

Багшийн ном нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлахуй, суралцахуйн үйл ажиллагааг зохион байгуулахад багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх хэвлэмэл материал юм.

Багшийн ном(цаашид “ном” гэх) ерөнхий болон тусгай шаардлага хангасан байна.

Нэг. Ерөнхий шаардлага

1.1.Сургалтын хөтөлбөрийн онцлог, зорилго, хэрэгжүүлэх арга замыг тайлбарласан байна.

1.2.Номыг ашиглах удирдамж, аргачлалыг тусгасан байна.

1.3.Ном нь зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.

1.4.Зохиогчийн эрхийн тухай хуульд заасны дагуу бүтээлийг хэсэгчлэн ашиглаж болох ба бүтээлийн зохиогч, эх сурвалжийг заавал дурдсан байна.

1.5.Зохиогчийн эрхээр хамгаалагдсан шинжлэх ухааны бичвэр мэдээлэл, утга зохиол, урлагийн бүтээл, дуу авиа бүхий дүрст бүтээл, гэрэл зургийг ашиглах бол зохиогчоос зөвшөөрөл авсан байна.

Хоёр. Тусгай шаардлага

2.1.Агуулга, арга зүй, үнэлгээнд тавих шаардлага

2.1.1.Боловсролын тухайн түвшний болон судлагдахууны сургалтын хөтөлбөр, суралцагчийн номны уялдаа холбоог тусгасан байна.

2.1.2.Судлагдахууны агуулгын өргөсөл, гүнзгийрлийг боловсролын түвшин, анги бүрээр тодорхойлсон байна.

2.1.3.Боловсролын түвшин, анги, судлагдахууны агуулгын хүрээнд хэрэглэх нэр томъёоны тайлбар нь шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв, алдаагүй байна.

2.1.4.Судлагдахууны сургалтын хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүн, агуулга, арга зүй, орчин, үнэлгээний уялдаа холбоог тодорхойлсон байна.

2.1.5.Судлагдахууны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн алхмуудыг жишээгээр тайлбарласан байна.

2.1.6. Судлагдахууны сургалтын хөтөлбөрт заасан суралцагчийн эзэмших мэдлэг, чадварыг хөгжүүлэх арга зүйг зөвлөмжилсөн байна.

2.1.7. Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг хэрэгжүүлэх, суралцагчийн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн танхимын болон танхимын бус жишиг үйл ажиллагааг боловсруулж, тусгасан байна.

2.1.8. Жишиг үйл ажиллагаа нь зорилго, хэрэгжүүлэх арга зүйн алхам, ашиглах хэрэглэгдэхүүн, явцын үнэлгээний аргачлалыг багтаасан байна.

2.1.9. Жишиг үйл ажиллагааг суралцагчийн номын сэдэв, арга зүй, үнэлгээ, дасгал даалгаврын дарааллыг баримтлан боловсруулсан байна.

2.1.10. Жишиг үйл ажиллагаа нь бусад судлагдахуунтай интеграцчилсан, ахуй амьдралын бодит асуудлыг шийдвэрлэх, бие даан болон хамтран суралцахуй, суралцагч төвтэй арга зүйг дэмжсэн шийдэлтэй байна.

2.1.11. Суралцагчийн буруу төсөөлөл, алдаатай ойлголтыг илрүүлэх, засах тайлбар, зөвлөмжийг тусгасан байна.

2.1.12. Суралцагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулга хийх аргачлал, зөвлөмжийг тусгасан байна.

2.1.13. Тухайн ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх цагийн жишиг хуваарилалттай байна.

2.1.14. Суралцагчийн номын дасгал, даалгаврын хариу, хүндэвтэр, ахисан түвшний даалгаврыг гүйцэтгэх аргачлал, зааврыг тусгасан байна.

2.1.15. Тодорхой сэдвийн хүрээнд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг оношлох, ахиц, амжилтыг илрүүлэх, суралцахуйн үр дүнг үнэлэх жишиг шалгуур, дасгал, даалгаврын жишээ, хэрэглэж болох эх сурвалж, зөвлөмжтэй байна.

2.1.16. Үнэлгээний үр дүнд суурилан суралцахуйн үйл ажиллагааг сайжруулах, урамшуулах, сурлагын амжилтыг ахиулах зөвлөмжтэй байна.

2.2. Хэл найруулгад тавих шаардлага

2.2.1. Бичвэр мэдээлэл нь хэл найруулга, зөв бичгийн дүрмийн алдаагүй, ойлгомжтой байна.

2.2.2. Үг хэллэг, нэр томъёог сургалтын хөтөлбөрт нийцүүлэн, нэг нэршлээр жигд хэрэглэсэн байна.

2.3. Дизайнд тавих шаардлага

2.3.1. Зураг, хүснэгт, схем, инфографик болон бусад дүрслэл нь үнэн зөв, ойлгомжтой, тод харагдахуйц, нэр, тайлбартай байна.

2.3.2. Номын эх бэлтгэлд “5553-1:2005 Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага. 1-р хэсэг. Ном, товхимол” стандарт, ашигласан эх сурвалж, нэмэлт материалд MNS 5271:2012 стандарт, цахим материалд MNS 5638:2012 стандартыг тус тус баримтална.

2.4. Нэмэлт хэрэглэгдэхүүнд тавих шаардлага

2.4.1. Сургалтын хөтөлбөрт нийцсэн баталгаат эх сурвалж, цахим материалыг ашиглах холбоос, заавар, аргачлалыг тусгасан байна.

2.4.2. Судлагдахууны онцлогт нийцүүлэн хичээлд хэрэглэх ажлын хуудас боловсруулсан тохиолдолд хэвлэх, хувилах боломжтой байхаар тусгасан байна.

2.4.3.Цахим сургалтын платформд байршсан интерактив хичээл, хэрэглэгдэхүүнийг сурах бичгийн агуулгад нийцүүлэн сонгож хэрэглэх зөвлөмжийг тусгасан байна.

2.4.4.Багшлахуй, суралцахуйн үйл ажиллагаанд хиймэл оюун, технологийн дэвшлийг судлагдахууны онцлогт тохируулан ашиглах зөвлөмжийг тусгасан байна.

2.4.5.Цахим эх сурвалж, материал ашиглах тохиолдолд эдгээр нь интернэтийн хурд бага, эсхүл интернэтгүй орчинд ажилладаг, хувийн мэдээлэл шаардахгүй, үнэ төлбөргүй ашиглах боломжтой байна.

2.4.6.Цахим эх сурвалж ашигласан тохиолдолд “Creative Commons”-ийн эрхийг дурдсан байна.

---oOo---